



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/68/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: Утас: 88011833 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Г.Ганчимэг Утас:88268424 Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан	12
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР СУМЫН СООГО
СЕЙКЕО СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ОЮУНБИЛЭГ ТАНАА 7

Аудитын гэрчилгээний № 1186

танай _____ -ны № _____ -т

Г _____ 7

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын Соого Сейкео сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын Соого Сейкео сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын Соого Сейкео сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020044


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал С.Оюунбилиг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.02.08-аас 2020.02.09-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.14-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газар-т 2020.01.20-ний өдөр, аудит хийлгэх хүсэлтээ 2020.01.07 ний өдрийн 01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Сургууль, багш, эцэг эхийн хамтын үйл ажиллагааг идэвхжүүлж, сурагч бүрээ дэмжсэн хичээл, практикийг хослуулан чадвараа хэрэглээ болгон амьдрах чадвартай зөв монгол хүнийг төлөвшүүлэхэд оршино.

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Боловсролын стандартаар бага, суурь боловсрол эзэмшүүлэх

- Сургууль, багш, эцэг эхийн хамтын үйл ажиллагааг идэвхжүүлж, сурагч бүрээ дэмжсэн хичээл, практикийг хослуулан чадвараа хэрэглээ болгон амьдрах чадвартай зөв монгол хүнийг төлөвшүүлэхэд оршино.
- Төлөвшил: Сахилга бат, дэг журам, эмх цэгцийг эрхэмлэнэ.
- Мэдлэг чадварын ахиц, амжилт, багш бүрийг чадваржуулна.
- Авьяасыг нээн хөгжүүлэх: Ээлжит хичээлийн жилээр хүүхэд бүрийн авьяасыг нээж чадваржуулна.
- Боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж: Хүүхэд бүрийн сайн талыг магтан дэмжинэ.
- Эрүүл мэнд: Хүүхэд бүрийг зөв дадал хэвшилтэй болгох гэсэн зорилтыг тодорхойл ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлого нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу

мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургууль нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Гүүк Софт" ХХК-ийн "Axplorer" программ хангамж ашиглаж байна.

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургууль дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 33 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 24 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг "дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 778767,9 мянган төгрөгөөс тооцон 15575,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2% буюу 15575,3 мянган төгрөгөөр тооцсон нь үр дүнгийн тайлангийн зардлыг суурь болгон сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5617,8

мянган төгрөгөөр буюу 6,2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	0	0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	31597,0	39335,2	7738,1
Үндсэн хөрөнгө	996130,7	1026980,1	27849,4
Хуримтлагдсан элэгдэл	-129314,4	-173519,9	-44305,5
Нийт хөрөнгө	898413,3	892795,5	5617,8
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	898413,3	892795,5	5617,8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	898413,3	892795,5	5617,8

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгөөр 7738,2 мянган төгрөгөөр өссөн нь тайланд онд худалдаж авсан сургалтын хэрэглэгдэхүүн болон аж ахуйн материалын үлдэгдлээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд 2015-2019 онд худалдаж авсан 39335,1 мянган төгрөгийн материал байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өссөн нь төсвийн хөрөнгөөр 20878,2 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авсан, БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар 9971,2 мянган төгрөгийн ном үнэ төлбөргүй шилжиж ирснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн данснаас акталсан, шилүүлсэн хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгийн дансанд 770,0 мянган төгрөгөөр “Гүүк Софт” ХХК-иас санхүүгийн “Axplorer” программ худалдан авч биет хөрөнгийн данс 770,0 мянган төгрөгөөр өссөн байна.

Тайлант онд өглөгийн тооцооны дансаар 794,0 мянган төгрөгийн ажил гүйлгээг дамжуулан бүртгэсэн бөгөөд өглөг үүсээгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 892795,5 мянган төгрөг болж 5617,8 мянган төгрөгөөр буурсан үзүүлэлт нь тайлант үеийн үр дүнгийн зардлаар буурсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга гараагүй дахин үнэлгээний дансанд өөрчлөлт ороогүй байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургууль нь тайлант онд үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө батлагдаагүй бөгөөд Нийгмийн даатгалын газраас олгосон 173,1 мянган төгрөгийн шимтгэлийн зардлын урамшууллыг орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 7 зориулалтад 763665,5 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 16 ний өдрийн А/645 тоот захирамжаар 20100,0 мянган төгрөгийг хасч 743565,5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар тодотгож батлагджээ.

Нийт зардлын 678836,6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 64728,9 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 739898,5 мянган төгрөг буюу 99,5 хувьтай байгаа гүйцэтгэлээр цалингийн зардлаас 1116,1 мянга, ндш-зардлаас 1360,7 мянга тогтмол зардлаас 171,5, томилолтын зардлаас 168,2, үдийн цайны зардлаас 850,7 буюу улсын төсөвт 3495,5 мянга, орон нутгийн төсөвт 171,4 мянга нийт 3666,9 мянган төгрөгөөр хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Дээд шатны төсөв захирагч буюу аймгийн БСУГ-аас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны нэмэгдэл 7641,9 мянга, багш хөгжлийн хөтөлбөрийн 11000,0 мянга, түрээсийн орлогоор 798,3 мянган төгрөг нийт 19440,2 мянган төгрөгийг нэмэлтээр санхүүжүүлсэн бөгөөд зардлыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнасан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 28 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 27 асуудлыг алдаа, зөрчилгүйд тооцлоо.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Аудитаар алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

2.12 Шилэн дансны мэдээлэл: Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургууль нь Санхүүгийн тайлан хагас жилээр, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл 1-9 дүгээр саруудад хоцроож мэдээллийг хугацаа хоцорсон нийт 11 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Үүнд:

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуул аагүй
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	3	1	
3	Улирал бүр	1	4	4		
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	86	10	
6	Нийт	27	151	140	11	

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна.

2.15 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор сумын Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

1.1 Илрүүлэлт:

Тус байгууллагын программ хангамжийн дансанд 1570,0 мянган төгрөгийн нийт 4 төрлийн биет бус хөрөнгө бүртгэсэн байна тухай хөрөнгийг үзэхэд 2010 оны 200,0 мянган төгрөгийн үнэтэй "Архив"-ийн 2012 оны 150,0 мянган төгрөгийн үнэтэй "Монгол хэлний" 2008 онд 450,0 мянган төгрөгийн үнэтэй санхүүгийн "Acolous" программууд ашиглалтгүй, элэгдлийн хугацаа дууссан 800,0 мянган төгрөгийн программ байна.

1.2. Эрсдэл:

Ашиглалтгүй биет бус хөрөнгийг нягтлан бүртгэл, тайлангаас хасаагүй байх

1.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу ашиглалтгүй байгаа программ хангаж судалж холбогдох журмын дагуу шийдвэрлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31597077.00</u>	<u>39335261.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	31597077.00	39335261.00
351	Түүхий эд материал	82300.00	128000.00
35130	Эм боох материал	82300.00	128000.00
354	Хангамжийн материал	31514777.00	39207261.00
35410	Бичиг хэргийн материал	5225784.00	8354300.00
35420	Аж ахуйн материал	23345592.00	27087460.00
35440	Түлш, шатах тослох материал	198400.00	0.00
35450	Барилгын засварын материал	1157000.00	2177500.00
35470	Бусад хангамжийн материал	1588001.00	1588001.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>866816304.76</u>	<u>853460252.31</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	866816304.76	853460252.31
392	Биет хөрөнгө	658341304.76	644429141.21
39201	Барилга, байгууламж, орон сууц	563585500.00	563585500.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-18786183.36
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	109765029.87	114074029.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	-77303107.01	-91944610.13
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62138554.39	73351854.39
39208	Хуримтлагдсан элэгдэл	-51211375.52	-58569655.63
39214	Бусад үндсэн хөрөнгө	37041500.00	37041500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-3205596.96
39217	Ном	14325203.03	28882303.03
393	Биет бус хөрөнгө	208475000.00	209031111.10
39301	Програм хангамж	800000.00	1570000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-800000.00	-1013888.90
39303	Бусад биет бус хөрөнгө	208475000.00	208475000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>898413381.76</u>	<u>892795513.31</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>898413381.76</u>	<u>892795513.31</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	898413381.76	892795513.31
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	462571101.29	462571101.29
51101	Өмч: - төрийн	462571101.29	462571101.29
512	Хуримтлагдсан үр дүн	-55518908.47	-61136776.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-55518908.47	-55518908.47
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-5617868.45
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	491361188.94	491361188.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>898413381.76</u>	<u>892795513.31</u>

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	603477334.60	773150088.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3934767.60	10144388.00
120	Нийтлэг татварын бус орлого	3934767.60	10144388.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3934767.60	10144388.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	173188.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3934767.60	9971200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	599542567.00	763005700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	577163800.00	678836600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	577163800.00	678836600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1706580.00	19440200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1487700.00	18641900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	218880.00	798300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	64728900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		64728900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	632502366.62	778767956.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	632502366.62	778767956.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	561600611.62	736965524.45
2101	Цалин хөле болон нэмэгдэл урамшил	406306843.00	531540552.00
210101	Үндсэн цалин	393861684.00	487835327.00
210104	Урамшуулал	12445159.00	43705225.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49208053.00	66914833.00
210201	Тэтгэврийн даатгал	49208053.00	45915347.99
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	5401805.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	4267684.42
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	1029999.55
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	10299995.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56369986.00	57962471.00
210301	Гэрэл, цахилгаан	2859828.00	2862593.00
210302	Түлш, халаалт	32510000.00	34987310.00
210303	Цэвэр, бохир ус	21000158.00	20112568.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5069500.00	8764316.00
210401	Бичиг хэрэг	1835300.00	3524874.00
210402	Тээвэр, шатахуун	595200.00	1192000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1098700.00	1606200.00
210404	Ном, хэвлэл	117000.00	67500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	180000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	321720.00	1853742.00

Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1101580.00	340000.00
2105	Нормативт зардал	30000.00	963300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30000.00	538300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	425000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4117950.00	4951000.00
210602	Тавилга	0.00	333000.00
210604	Урсгал засвар	4117950.00	4618000.00
2107	Томиллолт, зочны зардал	696400.00	1937000.00
210702	Дотоод албан томиллолт	696400.00	1937000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	763100.00	13204600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	563100.00	12804600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39038779.62	50727452.45
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	969500.00	1050250.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1342500.00	5471750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36726779.62	44205452.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70901755.00	41802432.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	70222387.00	38135450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36192000.00	34072200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	345400.00	4063250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	3495553.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		3495553.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	679368.00	171429.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	679368.00	171429.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-29025032.02	-5617868.45
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-29025032.02	-5617868.45

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	599542567.00	763005700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	599542567.00	763005700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	577163800.00	678836600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	577163800.00	678836600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1706580.00	19440200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1487700.00	18641900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	218880.00	798300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	0.00	64728900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		64728900.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20672187.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	20672187.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	597449767.00	742127500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	597449767.00	742127500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	526548012.00	700325068.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406644696.00	530985644.00
210101	Үндсэн цалин	324422896.00	409015420.00
210102	Нэмэгдэл	57329500.00	69598924.00
210104	Урамшуулал	24892300.00	52371300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48870200.00	67296553.00
210201	Тэтгэврийн даатгал	48870200.00	47766871.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	4817100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	3853500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	963500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	9895582.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56369986.00	58057471.00
210301	Гэрэл, цахилгаан	2859828.00	2957593.00
210302	Түлш, халаалт	32510000.00	34987310.00
210303	Цэвэр, бохир ус	21000158.00	20112568.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3572400.00	6694700.00
210401	Бичиг хэрэг	1213000.00	2348000.00
210402	Тээвэр, шатахуун	793600.00	993600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	762700.00	1718200.00
210404	Ном, хэвлэл	136000.00	67500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	180000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	667100.00	1387400.00
2105	Нормативт зардал	317600.00	1437600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	112300.00	584000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	205300.00	853600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4535450.00	5447700.00
210602	Тавилга	0.00	877200.00
210604	Урсгал засвар	4535450.00	4570500.00
2107	Томилолт, зочны зардал	531400.00	1937000.00
210702	Дотоод албан томилолт	531400.00	1937000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1178200.00	16598600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	978200.00	16198600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4528080.00	11869800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1321500.00	3630000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3206580.00	8239800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70901755.00	41802432.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	70222387.00	38135450.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	20672187.00	
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36192000.00	34072200.00

213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13012800.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	345400.00	4063250.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	3495553.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		3495553.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	679368.00	171429.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	679368.00	171429.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	2092800.00	20878200.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	2092800.00	20878200.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2092800.00	20878200.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2092800.00	20878200.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2092800.00	20878200.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-2092800.00	-20878200.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	462,571,101.29	491,361,188.94	-55,518,908.47	0.00	898,413,381.76
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	462,571,101.29	491,361,188.94	-55,518,908.47	0.00	898,413,381.76
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-5,617,868.45	0.00	-5,617,868.45
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	462,571,101.29	491,361,188.94	-61,136,776.92	0.00	892,795,513.31

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	577163796.00	576484432.00	743565500.00	739898518.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	577163796.00	576484432.00	743565500.00	739898518.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	527613596.00	526934232.00	704579400.00	701763068.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406644696.00	406644696.00	532101700.00	530985644.00
210101	Үндсэн цалин	324422896.00	324422896.00	409065500.00	409015420.00
210102	Нэмэгдэл	57329500.00	57329500.00	70664900.00	69598924.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24892300.00	24892300.00		
210104	Урамшуулал	0.00	0.00	52371300.00	52371300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48870200.00	48870200.00	68657200.00	67296553.00
210201	Тэтгэврийн даатгал	48870200.00	48870200.00	48080300.00	47766871.00
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	0.00	5144300.00	4817100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	0.00	4115400.00	3853500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	0.00	1028900.00	963500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	0.00	10288300.00	9895582.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	57045700.00	56369986.00	58228900.00	58057471.00
210301	Гэрэл, цахилгаан	3531200.00	2859828.00	3303400.00	2957593.00
210302	Түлш, халаалт	32510000.00	32510000.00	34832200.00	34987310.00
210303	Цэвэр, бохир ус	21004500.00	21000158.00	20093300.00	20112568.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4289700.00	4289700.00	8469600.00	8469600.00
210401	Бичиг хэрэг	1213000.00	1213000.00	2348000.00	2348000.00
210402	Тээвэр, шатахуун	793600.00	793600.00	993600.00	993600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	762700.00	762700.00	1718200.00	1718200.00
210404	Ном, хэвлэл	853300.00	853300.00	1842400.00	1842400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	0.00	180000.00	180000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	667100.00	667100.00	1387400.00	1387400.00
2105	Нормативт зардал	317600.00	317600.00	1437600.00	1437600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	112300.00	112300.00	584000.00	584000.00

Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	205300.00	205300.00	853600.00	853600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4539100.00	4535450.00	16500000.00	16500000.00
210602	Тавилга	0.00	0.00	10000000.00	10000000.00
210604	Урсгал засвар	4539100.00	4535450.00	6500000.00	6500000.00
2107	Томилолт, зочны зардал	531400.00	531400.00	2105200.00	1937000.00
210702	Дотоод албан томилолт	531400.00	531400.00	2105200.00	1937000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1498200.00	1498200.00	1224400.00	1224400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1298200.00	1298200.00	824400.00	824400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.00	200000.00	400000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3877000.00	3877000.00	15854800.00	15854800.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2377000.00	2377000.00	6500000.00	6500000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1500000.00	1500000.00	9354800.00	9354800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49550200.00	49550200.00	38986100.00	38135450.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	49550200.00	49550200.00	38986100.00	38135450.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36192000.0	36192000.0	34919700.00	34072200.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	13012800.0	13012800.0		
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	345400.0	345400.0	4066400.00	4063250.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	577163800.00	576484432.00	743565500.00	739898518.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	577163800.00	576484432.00	678836600.00	675341047.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	577163800.0	576484432.0	678836600.00	675341047.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	64728900.00	64557471.00
132001	Орон нутгийн төсвөөс			64728900.00	64557471.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	45	45	53	53
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	39	39	40	40
620003	Үйлчлэх ажилтан	5	5	12	12

Соого-Сейкео бүрэн дунд сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	768	768	768	806
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	768	768	768	806
630001	Төрийн өмчит ЕБС	768	768	768	806
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	49.0	49.0	53.0	53.0
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	37	37	41	41
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	12	12	12	12

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан
Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	19440200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	19440200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	19440200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	19440200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	19,440,200.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	19440200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	19440200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		18641900.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	798,300.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Г.ГАНЧИМЭГ 2020.02.14

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЭНЯМ 2020.02.14

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ 2020.02.14

